



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн  
2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/143/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.bulgan@audit.mn](mailto:www.bulgan@audit.mn)

Булган аймаг  
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn  
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул  
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл .....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	16
3.4. Материаллаг байдал .....	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	20
4. Менежментийн захидал .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.23 № 62

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


**006020156**

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

СТ-1А

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>160,656,088.83</b>	<b>197,430,862.34</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,026,112.49	150,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,876,112.49	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	150,000.00	150,000.00
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	150,000.00	150,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	155,629,976.34	197,280,862.34
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	26,830,699.00	28,186,851.00
35110	Тусгай зориулалттай материал	26,679,499.00	26,568,351.00
35130	Эм боох материал	151,200.00	1,618,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	128,799,277.34	169,094,011.34
35410	Бичиг хэргийн материал	554,900.00	665,900.00
35420	Аж ахуйн материал	-	32,947,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,708,986.00	8,708,986.00
35440	Түлш, шатах тослох материал	-	5,899,200.00
35450	Барилгын засварын материал	-	55,000.00
35460	Хүнсний материал	3,062,808.00	5,827,152.00
35470	Бусад хангамжийн материал	116,472,583.34	114,989,973.34
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,714,255,563.98</b>	<b>1,819,848,956.98</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,714,255,563.98	1,819,848,956.98
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,574,856,105.81	1,685,136,998.81

39201	Барилга, байгууламж, орон сууц	1,521,192,436.83	1,521,192,436.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(100,223,250.82)	(151,080,220.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,445,145.87	159,214,145.87
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,077,764.68)	(89,859,586.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	295,928,655.38	430,526,655.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(173,917,433.11)	(219,232,102.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,308,180.00	91,308,180.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,126,413.66)	(86,917,435.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	644,000.00	24,655,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,127,259.73)
39217	Ном	6,682,550.00	8,457,187.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>139,399,458.17</b>	<b>134,711,958.17</b>
39301	Програм хангамж	16,418,500.00	16,418,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(12,757,041.83)	(17,444,541.83)
39303	Бусад биет бус хөрөнгө	135,738,000.00	135,738,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,874,911,652.81</u></b>	<b><u>2,017,279,819.32</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,874,911,652.81</u></b>	<b><u>2,017,279,819.32</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,874,911,652.81</b>	<b>2,017,279,819.32</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,918,734,371.38	1,918,734,371.38
51101	Өмч: - төрийн	1,918,734,371.38	1,918,734,371.38
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(169,209,270.94)</b>	<b>(26,841,104.43)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(169,209,270.94)	(169,209,270.94)
51220	Тайлант үеийн үр дүн	-	142,368,166.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125,386,552.37	125,386,552.37
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,874,911,652.81</u></b>	<b><u>2,017,279,819.32</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>567,162,180.00</b>	<b>916,079,637.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,277,430.00</b>	<b>278,227,137.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	19,277,430.00	278,227,137.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,097,430.00	278,227,137.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,700,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,097,430.00	275,526,737.00
120005	Түрээсийн орлого	180,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>547,884,750.00</b>	<b>637,852,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	544,215,100.00	637,852,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	544,215,100.00	637,852,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,669,650.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,669,650.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>628,291,105.01</b>	<b>773,711,470.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>628,291,105.01</b>	<b>773,711,470.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	569,099,284.26	687,617,800.76
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	337,586,574.75	425,991,608.84
210101	Үндсэн цалин	337,586,574.75	315,973,205.31
210102	Нэмэгдэл	-	69,816,323.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,390,400.00
210104	Урамшуулал	-	31,811,680.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,413,808.76	53,896,108.42
210201	Тэтгэврийн даатгал	61,172,275.76	37,691,645.26

210202	Тэтгэмжийн даатгал	1,837,872.00	4,379,481.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,470,297.00	3,399,726.30
210204	Ажилгүйдлийн даатгал	357,578.00	776,059.28
210205	Эрүүл мэндийн даатгал	3,575,786.00	7,649,196.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,046,139.00</b>	<b>32,263,329.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,452,739.00	5,909,629.25
210302	Түлш, халаалт	18,468,200.00	23,829,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,125,200.00	2,524,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,914,717.25</b>	<b>19,054,941.00</b>
210401	Бичиг хэрэг	2,834,380.00	1,687,133.00
210402	Тээвэр, шатахуун	4,261,199.00	1,492,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,783,278.25	1,497,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	5,667,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,035,860.00	3,912,460.00
210408	Бараа материал акталсны зардал	-	4,797,848.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,824,540.00</b>	<b>7,758,082.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	243,900.00	597,450.00
210502	Хоол, хүнс	19,726,640.00	7,160,632.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	854,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,934,900.00</b>	<b>3,324,860.00</b>
210604	Урсгал засвар	4,934,900.00	3,324,860.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,161,100.00</b>	<b>151,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,161,100.00	151,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,150,000.00</b>	<b>1,019,600.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	359,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,000.00	659,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>98,067,504.50</b>	<b>144,158,071.25</b>

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,719,645.00	8,598,827.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,347,859.50	135,559,244.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	59,191,820.75	86,093,669.73
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,882,900.00	522,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,832,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	522,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	28,308,920.75	85,570,769.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,308,920.75	85,570,769.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(61,128,925.01)</u></b>	<b><u>142,368,166.51</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(61,128,925.01)</u></b>	<b><u>142,368,166.51</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>548,313,350.00</u></b>	<b><u>640,552,900.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>180,000.00</b>	<b>2,700,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	180,000.00	2,700,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,700,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,700,400.00
120005	Түрээсийн орлого	180,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>548,133,350.00</b>	<b>637,852,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	544,263,700.00	637,852,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	544,263,700.00	637,852,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,669,650.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,669,650.00	-

<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	200,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>548,313,350.00</b>	<b>640,552,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>548,313,350.00</b>	<b>640,552,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>489,121,529.25</b>	<b>554,459,230.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	362,996,712.00	423,980,119.27
210101	Үндсэн цалин	361,671,212.00	313,961,715.74
210102	Нэмэгдэл	-	69,816,323.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,325,500.00	8,390,400.00
210104	Урамшуулал	-	31,811,680.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,423,797.00	51,031,485.50
210201	Тэтгэврийн даатгал	47,423,797.00	34,827,022.34
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,379,481.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,399,726.30
210204	Ажилгүйдлийн даатгал	-	776,059.28
210205	Эрүүл мэндийн даатгал	-	7,649,196.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,474,639.00	35,087,529.25
210301	Гэрэл, цахилгаан	5,452,739.00	5,909,629.25
210302	Түлш, халаалт	18,896,700.00	26,653,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,125,200.00	2,524,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,591,271.25	16,238,500.00
210401	Бичиг хэрэг	1,441,250.00	1,759,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,474,683.00	1,492,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,537,478.25	1,497,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	7,070,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,137,860.00	4,418,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	21,322,960.00	11,493,576.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	260,100.00	718,600.00

210502	Хоол, хүнс	20,160,260.00	9,924,976.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	902,600.00	850,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,699,450.00</b>	<b>3,369,060.00</b>
210604	Урсгал засвар	4,699,450.00	3,369,060.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,161,100.00</b>	<b>151,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,161,100.00	151,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,265,830.00</b>	<b>1,019,600.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	359,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,000.00	659,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,185,770.00</b>	<b>12,088,160.25</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,185,770.00	12,088,160.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,191,820.75</b>	<b>86,093,669.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,882,900.00</b>	<b>522,900.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,832,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	522,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,308,920.75</b>	<b>85,570,769.73</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,308,920.75	85,570,769.73
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,918,734,371.38	125,386,552.37	(101,914,347.93)	1,942,206,575.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,166,062.00)	(6,166,062.00)
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,918,734,371.38</b>	<b>125,386,552.37</b>	<b>(108,080,409.93)</b>	1,936,040,513.82
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(61,128,861.01)	(61,128,861.01)
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,918,734,371.38</b>	<b>125,386,552.37</b>	<b>(169,209,270.94)</b>	1,874,911,652.81
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,918,734,371.38</b>	<b>125,386,552.37</b>	<b>(169,209,270.94)</b>	1,874,911,652.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,918,734,371.38</b>	<b>125,386,552.37</b>	<b>(169,209,270.94)</b>	1,874,911,652.81
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	142,368,166.51	142,368,166.51
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,918,734,371.38</b>	<b>125,386,552.37</b>	<b>(26,841,104.43)</b>	2,017,279,819.32

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	412868964.92	652399600.00	640552900.03
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	409756664.92	652399600.00	640552900.03
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	398470464.92	640329600.00	554459230.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	277634253.92	486782900.00	423980119.27
210101	Үндсэн цалин	0.00	269536998.92	346096500.00	313961715.74
210102	Нэмэгдэл	0.00	4187255.00	96691900.00	69816323.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3910000.00	8391100.00	8390400.00
210104	Урамшуулал	0.00	0.00	35603400.00	31811680.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	27989191.00	65715600.00	51031485.50
210201	Тэтгэврийн даатгал	0.00	27989191.00	46244400.00	34827022.34
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	4867800.00	4379481.16
210203	ҮОМШО-ний даатгал	0.00	0.00	3894200.00	3399726.30
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	973600.00	776059.28
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	9735600.00	7649196.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	24352466.00	35364300.00	35087529.25
210301	Гэрэл, цахилгаан	0.00	5952466.00	6149400.00	5909629.25
210302	Түлш, халаалт	0.00	16490400.00	26690400.00	26653400.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1909600.00	2524500.00	2524500.00
210304	Байрны түрээс				
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	10746134.00	16239100.00	16238500.00
210401	Бичиг хэрэг	0.00	3595163.00	1759500.00	1759500.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	2876550.00	1493400.00	1492800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,652,371.00	1,497,500.00	1,497,500.00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	128,000.00	7,070,200.00	7,070,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,494,050.00	4,418,500.00	4,418,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	29,195,450.00	18,078,700.00	11,493,576.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	247,300.00	718,600.00	718,600.00
210502	Хоол, хүнс	-	27,382,150.00	16,488,400.00	9,924,976.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,566,000.00	871,700.00	850,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	3,691,470.00	3,369,100.00	3,369,060.00
210604	Урсгал засвар	-	3,691,470.00	3,369,100.00	3,369,060.00

**Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	1,680,200.00	151,200.00	151,200.00
210702	Дотоод албан томилолт	-	1,680,200.00	151,200.00	151,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	2,547,000.00	2,539,900.00	1,019,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,480,000.00	1,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	360,000.00	360,000.00	359,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	692,000.00	659,900.00	659,900.00
210807	Газрын төлбөр	-	15,000.00	20,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	20,634,300.00	12,088,800.00	12,088,160.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	20,634,300.00	12,088,800.00	12,088,160.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	11,286,200.00	12,070,000.00	86,093,669.76
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	85,570,769.76
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	85,570,769.76
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	11,286,200.00	12,070,000.00	522,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	8,196,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	11,286,200.00	2,828,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	1,045,500.00	522,900.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,112,300.00</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	3,112,300.00	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	3,112,300.00	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	412,825,550.00	649,442,573.00	639,760,722.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	412,306,100.00	649,399,600.00	637,852,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	412,306,100.00	649,399,600.00	637,852,500.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	42,973.00	1,908,222.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-	42,973.00	1,908,222.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	519,450.00	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	519,450.00	-	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-	-	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)				
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)				
650003	Ажлын албаны албан хаагч (АА)				

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Н.Пүрэвсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, үндсэн хөрөнгө олж авах, цалингийн тооцооллыг үнэн зөв хийх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор П.Эрдэнэзул хариуцаж гүйцэтгэв.

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024”, “Мэргэжилийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр 2016-2021” зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн судалгаа шинжилгээ, инноваци, мэдээллийн технологид суурилсан “Чанартай сургалт-тогтвортой хөдөлмөр эрхлэлт” хэмээн зорилгоо тодорхойлж, дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

ХӨГЖИЛ-ийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2. МБС-ын салбарын ажилтан, албан хаагч, суралцагчдын эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг дэмжих, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг үе шаттай бүрдүүлнэ.

3. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, нийгмийн түншлэл, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4. Мэргэжлийн боловсрол, сургалтын цахим сургалтын платформ, бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, сургуулийн санхүүжилт, өөрийн орлогын бүрдүүлэлт, ашиглалтын оновчтой хэлбэрийг тогтоож мөрдүүлнэ.

Нэг. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг НОГООН ХӨГЖИЛ -ийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр:

1. Хөдөлмөрийн зах зээл болон мэргэжлийн боловсрол сургалтын бодлого, зохицуулалтыг үнэлж, дүгнэлт гаргана.
2. Үндэсний мэргэшлийн хүрээтэй уялдуулан мэргэжлийн чиглэл бүрээр сургалтын агуулгын залгамж чанар уялдааг хангасан, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, ажил мэргэжлийн лавлах, мэргэжлийн боловсрол, сургалтын ерөнхий шаардлага (стандарт), чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж сургалтад нэвтрүүлнэ.
3. Дэлхийн ур чадварын тэмцээний үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн сургалтын чанар, үр дүнг дээшлүүлнэ.
4. Сургалт, үйлдвэрлэлийн зардал, материалын нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах хэрэглээний дадлыг төлөвшүүлнэ.
5. Сургалтын чанарын үнэлгээ, төгсөгчдийн хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг авна.
6. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний нөөц, хүртээмжийг нэмэгдүүлж цахим санг бий болгон ашиглалтыг сайжруулна.
7. Цахим сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж цахим үнэлгээ хийх нөхцөл боломжийг бүрдүүлэн, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран иргэд, суралцагчдыг нээлттэй, уян хатнаар сургалтад хамруулна.
8. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрт шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний эрэлтийг тооцох, бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бүхэлд нь хамруулсан “Мэргэжлийн боловсрол сургалт-ажлын байр-тогтвортой хөдөлмөр эрхлэлт”-ийн зураглал, тооцооллыг гаргана.
9. Ажил олгогч, сургалтын байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагааг дэмжсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 773711.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15474.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142368.1 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	160656.0	197430.8	36774.7
Авлага	5026.1	150.0	-4876.1
Бараа материал	155629.9	197280.8	41650.8
Үндсэн хөрөнгө	1714255.5	1819848.9	105593.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1714255.5</b>	<b>1819848.9</b>	<b>105593.3</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>1874911.6</b>	2017279.8	142368.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1874911.6</b>	2017279.8	142368.1

Тус газар нь өмнөх оны 5026.1 мянган төгрөгийн авлагатай байсан ба тайлант онд 4876.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж 150.0 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 197280.8 мянган төгрөг болж 41650.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан материал болон дэд газраас материал шилжүүлж авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Байгууллагын даргын тушаалаар ашиглагддаггүй, эвдэрсэн 4797.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1819848.9 мянган төгрөг болж 105593.3 мянган төгрөгөөр өссөн нь харьяалагдах яам, гадаад хөрөнгө оруулалтаас хөрөнгө

нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 241152.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй.

Тайлант хугацаанд өр төлбөр үүсгээгүй ажилласан байна.

Урт хугацааны өр төлбөр үүсгээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2017279.8 мянган төгрөг болж 142368.1 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалжээ

Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 348917.4 мянган төгрөгөөр буюу 61.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хандив тусламжаар ирсэн орлого байна. Энэ нь өөрийн байгууллагын хөрөнгө нэмэгдэж мөн бараа материал байгууллагын үйл ажиллагаа хэвийн доголдолгүй явагдана гэж үзэж байна.

Нийт зардал өмнөх оноос 145420.3 мянган төгрөгөөр буюу 23.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс 88405.1 мянган төгрөг, байр ашиглалтай холбоотой зардал 6217.2 мянган төгрөг, хангамжийн зардал 9140.2 мянган төгрөгийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү нягтлан бодох бүртгэлийн залруулга бичилт байхгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Хөдөө аж ахуйн Мэргэжил сургалт үйлдвэрийн төв нь 2020 оны төсвийн төслийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төсөөлөл байхгүй байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 652399.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 649399.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 3000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 637852.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2700.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. Урсгал үйл ажиллагаанд 554982.1 мянган төгрөгийг зарцуулж 85570.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 554982.1 мянган төгрөг буюу 85 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 62802.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын зардлыг

14684.1 мянган төгрөгөөр, хоол хүнс 6585.1 мянган төгрөгийг тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 8196.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 2828.0 мянган төгрөгийг олгоогүй улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ 85570.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 8196.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 2828.0 мянган төгрөгийг олгоогүй, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 13.5 хувиар төлөхөөр тооцоолсон боловч 12.5 хувиар төлж хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 3000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2700.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 90 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Өөрийн орлого	3000.0	2700.4	0	90
<b>Нийт дүн</b>	<b>3000.0</b>	<b>2700.4</b>	<b>0</b>	<b>90</b>

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагад нэмэлт санхүүжилтээр орсон орлого, зарлага байхгүй болно.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 147 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа хоцроосон 2 мэдээлэл хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны хэрэгжүүлэлт 90 хувьтай хэрэгжсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ороогүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4807.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 345.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 4525.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 4807.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 345.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоов.

Үүнд:

1. Албан хаагчдын цалингийн нэмэгдлийг 1-4 дүгээр саруудад ажилласан хугацаанд ноогдсон цалингаас бодоогүй ажиллавал зохих цалингаас тооцож илүү 345.1 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

#### Шийдвэрлэсэн нь:

Албан хаагчдад илүү олгосон 345.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг аудитын явцад барагдуулав.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4525.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Үндсэн хөрөнгийн авто машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дууссан хөрөнгүүдийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийн дагуу өөрчлөлт хөдөлгөөнийг хийж тайлагнах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **Цалингийн зардалтай холбоотой асуудал**

1.1 Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн цалингийн зардлаас төлж бүлэг хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан тул зөвлөмж өгөх

1.2 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.3 Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах,

1.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

2.1. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас ХХОАТ-т төлж бүлэг хооронд зарцуулсан тул зөвлөмж өгөх

2.2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.3. Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах,

2.4. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн

3.1. Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн тул зөвлөмж өгөх

3.2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4" үнэн зөв байх" , санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

3.3. Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах,

3.4. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

4.1 Тус байгууллагын цалингийн зардлын тооцооллыг тулган баталгаажуулахад цалингийн шатлал бууруулсан албан хаагчдын үндсэн цалинг бууруулахгүй суутгалын бүлэгт суутгаж, үр дүнгийн тайланд 649482 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

4.2 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 5.1.4 "үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна зөвлөмж өгөх

4.3 . Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах,

4.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

### **Авлагатай холбоотой асуудал**

5.1 Санхүүгийн тайлангийн тооцооллыг бүрэн хийж хэвших, урьд оны авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

5.2 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалтыг зөрчсөн тул зөвлөмж өгөх

5.3 Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах,

5.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

### **Зардлын данстай холбоотой асуудал**

6.1 Бичиг хэргийн зардлаас 122783 төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.

6.2 Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Сангийн сайдын 55 дугаар тушаалуудыг тус тус зөрчсөн тул зөвлөмж өгөх

6.3 Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах,

6.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

### **7. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

7.1. Үндсэн хөрөнгийн авто машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй 49 нэр төрлийн үндсэн хөрөнгө байна.

7.2. УСНББОУС 16 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоол хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх

7.3. УСНББОУС 16 "Үндсэн хөрөнгө", Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

7.4. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

## **8 Шилэн данстай холбоотой асуудал**

8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

8.2 Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул зөвлөмж өгөх

8.3 Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах

8.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

### **АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2020</b>	Аудитын нэр: <b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2020/143/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>ХАА-н мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв</b>	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн цалингийн зардлаас төлж бүлэг хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан тул зөвлөмж өгөх Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн байна.	1,407.8	Хууль, журам хэрэгжүүлж ажиллах. зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
2	Албан хаагчдын цалингийн нэмэгдлийг 1-4 дүгээр саруудад ажилласан хугацаанд ноогдсон цалингаас бодоогүй ажиллавал зохих цалингаас тооцож илүү олгосон байна. Хууль, журмыг мөрдөж ажиллах.	345.1	Аудитын явцад барагдуулсан	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
3	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас ХХОАТ төлж бүлэг хооронд зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн байна.	1,464.0	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
4	Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4" үнэн зөв байх" , санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.	668.9	Тооцооны дансаар дамжуулж, стандартын дагуу НББ хөтөлж байх зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
5	Тус байгууллагын цалингийн зардлын тооцооллыг тулган баталгаажуулахад цалингийн шатлал бууруулсан албан хаагчдын үндсэн цалинг бууруулахгүй суутгалын бүлэгт суутгаж, үр дүнгийн тайланд 649482 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна . Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 5.1.4 "үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, үнэн зөв	649.4	Хууль, журам хэрэгжүүлж ажиллах. зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат

	байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.				
6	Санхүүгийн тайлангийн тооцооллыг бүрэн хийж хэвших, урьд оны авлагыг барагдуулж ажиллах	150.0	Хууль, журам хэрэгжүүлж ажиллах. зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
7	Бичиг хэргийн зардлаас 122783 төгрөгийн зориулалт бус зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Сангийн сайдын 55 дугаар тушаалуудыг тус тус зөрчсөн байна.	122.7	Хууль, журам хэрэгжүүлж ажиллах. зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
8	Үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгө, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил дансанд ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй 49 нэр төрлийн 98634.8 мянган төгрөгийн хөрөнгө байгаа нь УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	0	УСНББОУС-17 Хууль, журам хэрэгжүүлж ажиллах. зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	0	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Н.Пүрэвсайхан Т.Ариунбат
	<b>Дүн</b>	<b>4807.9</b>			